



Хүний Эрх Хөгжил Төв  
CHRD

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ,  
ШИЙДВЭР ГАРГАХАД ОРОЛЦОХ, ЭРХЭЭ  
ХАМГААЛУУЛАХ ТАЛААРХ ААРХУСЫН КОНВЕНЦ**

**( Хүний эрх хөгжил төвийн орчуулга)**

Улаанбаатар хот  
2011 он

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ, ШИЙДВЭР ГАРГАХАД  
ОРОЛЦОХ, ЭРХЭЭ ХАМГААЛУУЛАХ ТАЛААРХ ААРХУСЫН КОНВЕНЦ  
1998 оны 06 сарын 25-ны өдөр**

Энэхүү Конвенцэд нэгдэгч улсууд нь

Хүний Хүрээлэн буй орчны асуудлаарх Стокхольмын Тунхаглалын 1-р зарчмыг сануулан,

Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн асуудлаарх Риогийн Тунхаглалын 10-р зарчимд үндэслэн,

Байгаль орчны тухай Дэлхийн Тунхагийн талаарх Ерөнхий Ассамблейн 1982 оны 10 сарын 28-ны өдрийн 37/7 тоот болон хүний сайн сайхан аж төрөхөд нийцсэн эрүүл орчинг баталгаажуулах хэрэгцээ шаардлагын талаарх 1990 оны 12 сарын 14-ний өдрийн 45/94 тоот шийдвэрүүдэд тулгуурлаж,

Германы Франкфурт хотноо 1989 оны 12 сарын 8-ны өдөр Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан Хүрээлэн буй орчин ба Эрүүл мэндийн асуудлаарх Европын Бага хурлаас батлагдсан Хүрээлэн буй орчин ба Эрүүл мэндийн талаарх Европын Тунхагийг харгалзан үзэж,

Хүрээлэн буй орчныг хамгаалах, хадгалан үлдээх, нөхцлийг нь сайжруулах, байгаль орчинд чиглэсэн тогтвортой хөгжлийг баталгаажуулах шаардлагыг нотлон,

Байгаль орчныг зохих түвшинд хамгаалах нь хүн төрөлхтөний сайн сайхан, хүний үндсэн эрхүүд, үүний дотор амьд явах эрхийг нь эдлүүлэхэд нэн чухал болохыг хүлээн зөвшөөрч,

Хүн бүр эрүүл, сайн сайхан аж төрөхөд нийцэхүйц орчинд амьдрах эрхтэй, түүнчлэн өнөө болон ирээдүй үеийнхнийхээ тусын тулд, дангаараа болон бусадтай хамтран байгаль орчныг хамгаалах, нөхцлийг нь сайжруулах үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрч,

Энэхүү эрхийг баталгаажуулах, үүргээ биелүүлэхийн тулд иргэд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах боломжтой байх ёстойг харгалзан үзэж, үүнтэй холбогдуулан уул эрхийг нь эдлүүлэхийн тулд иргэдэд тусалцаа хэрэгтэй болохыг хүлээн зөвшөөрч,

Байгаль орчны салбарт мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох боломжоор хангах явдал нь аливаа шийдвэрийн чанар, хэрэгжилтийг сайжруулах, байгаль орчны асуудлаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт үзэл бодлоо илэрхийлэх болон төрийн албан тушаалтнуудын зүгээс тэдний дуу хоолойг сонсох боломжийг олгодог болохыг харгалзан,

Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцыг ил тод, хариуцлагатай болгох, шийдвэр гаргахад олон нийтийн дэмжлэгийг өрнүүлэхэд чиглэн,

Засгийн газар бүх салбартаа ил тод байдлыг хэвшүүлэх эрмэлзлийг хүлээн зөвшөөрч, энэхүү Конвенцийн зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг хууль тогтоох байгууллагуудаас хүсч,

Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад оролцох үйл явцын талаар мэдэж байх болон мэдээллийг чөлөөтэй олж авах, олж авсан мэдээллээ хэрхэн ашиглах талаарх олон нийтийн хэрэгцээ, шаардлагыг хүлээн зөвшөөрч,

Байгаль орчноо хамгаалахад хувь хүмүүс, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудын үүрэг, оролцооны чухлыг мөн хүлээн зөвшөөрч,

Байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих, байгаль орчин болон тогтвортой хөгжилд нөлөөлөх шийдвэр гаргахад оролцох, олон нийтийг өргөн хүрээний мэдлэгтэй болгох явдлыг дэмжихийг эрмэлзэн,

Энэ тохиолдолд, харилцааны өргөн тархаж буй хэлбэр болох хэвлэл мэдээлэл, цахим болон бусад механизмуудыг ашиглахын чухлыг тэмдэглэн,

Засгийн газар шийдвэр гаргахад байгаль орчны асуудлуудыг бүрэн харгалзан үзэж байхын чухлыг болон байгаль орчны сүүлийн үеийн, тодорхой мэдээллийг нэгтгэж байх төрийн албан тушаалтнууд цаашид хэрэгтэй болохыг хүлээн зөвшөөрч.

Төрийн албан тушаалтнууд нийтийн ашиг сонирхлын үүднээс байгаль орчны мэдээллийг цуглуулдаг болохыг хүлээн зөвшөөрч.

Хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, хууль хэрэгжих явдлыг хангахын тулд шүүхийн үр нөлөө бүхий механизм олон нийтэд, ялангуяа байгууллага бүрт хүрч үйлчилж чаддаг байх нь зүйтэй болох.

Хэрэглэгчдэд байгаль орчныг харгалзсан сонголт хийх боломж олгохын тулд хэрэглэж буй бараа бүтээгдэхүүнийх нь талаарх зохих мэдээллийг өгөхийн чухлыг тэмдэглэн.

Хүрээлэн буй орчинд генийн өөрчлөлттэй организмыг зориудаар нэвтрүүлэх үйлдлийг олон нийтийн зүгээс хүлээн авч буй байдал хийгээд энэ салбарт шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоо, ил тод байх хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч.

Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх нь НҮБ-ын Европын эдийн засгийн хорооны (ЕЭЗХ) бүсэд ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах болохыг ойлгон.

ЕЭЗХ-ны энэ талаар оруулсан хувь нэмрийг тэдгээрийн дотроос 1995 оны 10 сарын 25-ны өдөр Болгарын Софи хотноо зохион байгуулагдсан “Европын байгаль орчин” сэдэвт Сайд нарын гуравдугаар Бага хурлаас гарсан Сайд нарын тунхаглалын “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцооны талаарх ЕЭЗХ-ны удирдамж”-ийг цохон тэмдэглэж.

1991 оны 2 сарын 25-ны өдөр Финландын Эспү хотноо батлагдсан, Хил дамнасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Конвенцийн холбогдох заалтууд, 1992 оны 3 сарын 17-нд Хелсинкэд тус тус батлагдсан Үйлдвэрлэлийн ослын хил дамнасан нөлөөллийн тухай Конвенц болон Хил дамнасан ус болон олон улсад хамаарах нууруудыг ашиглах, хамгаалах тухай Конвенциуд болон бусад бүсийн хэмжээний конвенциудыг санаандаа авч.

Энэхүү Конвенцийг батлах нь “Европын байгаль орчин”-ы үйл явцыг цаашид бэхжүүлэх, Дани улсын Аархус хотноо 1998 оны зургадугаар сард зохиогдох Сайд нарын дөрөвдүгээр Бага хурлын үр дүнд хувь нэмрээ оруулна гэдгийг ухамсарлан Дараах зүйлсийг харилцан тохиролцов.

## **Зүйл 1** **ЗОРИЛГО**

Хүн бүрийн болон хойч үеийнхнийхээ эрүүл мэнд, сайн сайхан орчинд амьдрах эрхийг нь хамгаалахад хувь нэмрээ оруулахын тулд Конвенцийн Гишүүн улс бүр энэхүү Конвенцийн зүйл заалтуудын дагуу байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах эрхийг нь баталгаажуулна.

## **Зүйл 2** **НЭР ТОМЪЁО**

Энэхүү Конвенцийн зорилгын дагуу,

1. “Талууд” гэдэгт энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол Конвенцид нэгдэн орсон талуудыг;
2. “Төрийн байгууллага, албан тушаалтан” гэдэгт:
  - а. Дотоодын, бүсийн болон бусад түвшний засгийн газар;
  - б. Дотоодын хууль тогтоомжийн дагуу нийтийн захиргааны үүргийг, үүний дотор байгаль орчинтой холбоотой тусгай үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж, үйлчилгээг хүргэж буй байгууллага, албан тушаалтан;

**в.** Энэ зүйлийн а болон б-д дурдсан байгууллага, албан тушаалтнуудын хяналт удирдлага дор байгаль орчинтой холбоотой төрийн үүрэг хариуцлагыг хүлээж, үйлчилгээг хүргэж буй бусад байгууллага, албан тушаалтнууд;

**г.** Энэхүү Конвенцийн 17-р зүйлд дурьдсан Конвенцид нэгдэн орсон, бүсийн нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын байгууллага;

Энэхүү тодорхойлолт нь хууль тогтоох болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллага, албан тушаалтанд хамаарахгүй болно.

3. “Байгаль орчны мэдээлэл” гэдэгт бичмэл, харагдах, сонсогдох, цахим болон бусад ямар ч хэлбэрээр байгаа:

**а.** Агаар, хийн мандал, ус, хөрс, газар, газрын болон байгалийн тогтоц, биологийн төрөл зүйл, тэдгээрийн бүрдлүүд, үүний дотор, генийн өөрчлөлттэй организмууд зэрэг хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийн харилцан үйлчлэлийн талаарх мэдээлэл;

**б.** Энэ зүйлийн а-д дурдсан байгаль орчныг бүрдүүлэгч элементүүдэд нөлөөлж байгаа болон нөлөөлж болох бодис, энерги, дуу чимээ болон цацраг, түүнчлэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүд, үүний дотор захиргааны арга хэмжээ, байгаль орчны гэрээ хэлэлцээрүүд, бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, мөн байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах гарах зардал, эдийн засгийн бусад анализ, таамаглалууд;

**в.** Байгаль орчныг бүрдүүлэгч элементүүд, эсхүл тэдгээр элементүүдийн нөхцөл байдлаас, мөн энэ зүйлийн б-д дурдсан хүчин зүйлс, үйл ажиллагаа, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа, өртөх магадлалтай хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний амьдралын нөхцөл, соёлын хүчин зүйлсийн талаарх мэдээлэл

4. “Олон нийт” гэдэгт нэг буюу түүнээс дээш хувь хүн, хуулийн этгээд болон дотоодын хууль тогтоомж, тогтсон практикийн дагуу бий болсон байгууллагууд, холбоод, бүлгүүдийг ойлгоно.

5. “Холбогдох олон нийт” гэдэгт байгаль орчны тухайн асуудлаар гаргах шийдвэрийн нөлөөлөлд өртсөн, өртөж болох, түүнчлэн ашиг сонирхол бүхий олон нийтийг ойлгох ба энэхүү тодорхойлолтод дотоодын хууль тогтоомжоор тавьсан шаардлагыг хангаж буй байгаль орчныг хамгаалах зорилготой төрийн бус байгууллагуудыг мөн хамруулна.

### **Зүйл 3**

#### **ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

1. Талууд нь энэхүү Конвенцийн зүйл заалтуудыг хэрэгжүүлэх ил тод, тодорхой, тууштай механизмыг бий болгохын тулд шаардлагатай эрх зүйн тохируулагч болон бусад арга хэмжээг, үүний дотор энэхүү Конвенцид дурдсан - мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах - заалтуудын харилцан уялдааг хангах, эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

2. Төрийн байгууллага, албан тушаалтнуудын зүгээс олон нийтийг байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулахад нь туслах, чиглүүлэх явдлыг баталгаажуулахыг Талууд эрмэлзэнэ.

3. Талууд нь олон нийтийн байгаль орчны мэдлэг боловсролыг, ялангуяа байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах асуудлаарх мэдлэгийг нь дээшлүүлэх явдлыг дэмжинэ.

4. Талууд нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллаж буй байгууллага, холбоод, бүлгүүдийг хүлээн зөвшөөрч, дэмжих бөгөөд энэхүү үүргээ үндэсний хууль тогтоомжид нийцүүлж баталгаажуулна.

5. Энэхүү Конвенцийн зүйл заалтууд нь конвенциор шаардсанаас илүүтэйгээр байгаль орчны мэдээлэл авах, шийдвэр гаргахад илүү өргөн хүрээнд оролцох, эрхээ хамгаалуулах өргөн боломжийг эдлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх Талуудын эрхийг үл хөндөнө.
6. Энэхүү Конвенц нь байгаль орчны мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрхийг доогуур үнэлэхгүй.
7. Талууд нь энэхүү Конвенцийн зарчмуудыг олон улсын түвшинд байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад болон байгаль орчны асуудлаарх олон улсын байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх явдлыг дэмжинэ.
8. Талууд нь энэхүү Конвенцийн зүйл заалтуудын дагуу эрхээ эдэлж буй хүмүүс, тийнхүү эрхээ эдэлснийхээ төлөө ямар нэг байдлаар шийтгэгдэх, мөрдөгдөн хавчигдах, зовохгүй байх явдлыг баталгаажуулна. Энэхүү заалт нь шүүхийн процесст зайлшгүй гарах зардлыг шийдвэрлэх дотоодын шүүхийн эрх хэмжээг үл хөндөнө.
9. Энэхүү Конвенцийн холбогдох зүйл заалтын хүрээнд олон нийт нь байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах эрхээ иргэний харьяалал, оршин суугаа газраас үл хамааран, хуулийн этгээдийн хувьд бүртгэгдсэн болон үйл ажиллагаагаа хаана явуулж буй эсэхээс үл хамааран эдэлнэ.

#### **Зүйл 4**

#### **МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ**

1. Энэ зүйлийн 2-т дурдагдсан төрийн байгууллага, албан тушаалтнууд нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд байгаль орчны талаар хүссэн мэдээллийг үүний дотор хүсэлт гаргасан тухай бүрт болон энэ заалтын дэд хэсэг b) –д дурдсан тохиолдолд уг төрлийн мэдээллийг агуулсан бодит баримтын хувийг олон нийтэд нээлттэй болгох явдлыг:
  - а.** Тухайлан илэрхийлэх ашиг сонирхолгүйгээр баталгаажуулна.
  - б.** Дор дурдсанаас бусад тохиолдолд хүсэлт гаргасан хэлбэрээр нь баталгаажуулна:
    - (i) төрийн байгууллага, албан тушаалтны хувьд өөр хэлбэрээр нээлттэй болгох нь хүндэтгэн үзэх үндэслэлтэй байвал;
    - (ii) тухайн мэдээлэл нь өөр хэлбэрээр олон нийтэд нээлттэй болсон;
2. Тухайн хүссэн мэдээллийн цар хүрээ, хэмжээнээс хамааран хүсэлт гаргаснаас хойш хоёр сар хүртэл сунгаж болохоос бусад тохиолдолд энэ зүйлийн 1-д хамаарах байгаль орчны мэдээллийг олон нийтэд аль болох даруйхан, хамгийн оройтлоо гэхэд хүсэлт гаргаснаас хойш нэг сарын дотор нээлттэй болгоно. Хүсэлт гаргагчид хугацааг сунгасан тухай болон сунгасан шалтгааныг мэдэгдэнэ.
3. Байгаль орчны мэдээллийг хүсч өргөдөл гаргагчид дараах тохиолдолд татгалзсан хариу өгч болно. Үүнд:
  - а.** Хүсэлтийг хандаж гаргасан албан тушаалтан нь тухайн байгаль орчны мэдээллийг хариуцдаггүй;
  - б.** Гаргасан хүсэлт нь илэрхий үндэслэлгүй, эсхүл хэт ерөнхий байдлаар томъёологдсон;
  - в.** Боловсруулалтын шатандаа байгаа эсхүл нийтийн ашиг сонирхлыг харгалзан үндэсний хууль тогтоомж, заншил, тогтсон практикийн дагуу төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой материалыг хүссэн;
4. Байгаль орчны мэдээллийг нээлттэй болгох нь дор дурдсан байдалд нөлөөлөхөөр бол хүсэлтийг хангахаас татгалзаж болно. Үүнд:
  - а.** Үндэсний хууль тогтоомжоор нууцад хамааруулсан төрийн үйл ажиллагааны нууц мэдээлэл;

- б. Олон улсын харилцаа, дотоодын батлан хамгаалах, эсхүл нийтийн аюулгүй байдал;
- в. Шүүхээр эрхээ хамгаалуулах, шударга шүүхээр шүүлгэх эрх, эрүүгийн болон сахилгын чиглэлээр мөрдөн байцаалт явуулах төрийн албан тушаалтны бүрэн эрх;
- г. Эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд хуулиар хамгаалагдсан, худалдааны болон үйлдвэрлэлийн мэдээллийн нууц;
- д. Оюуны өмчийн эрх;
- е. Үндэсний хууль тогтоомжоор нууцад хамааруулсан мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоор өөртэй нь зөвшилцөөгүй тохиолдолд хувь этгээдэд хамаарах хувийн мэдээлэл болон файлын найдвартай байдал;
- ё. Тухайн хүссэн мэдээллийг бий болгосон хуулийн хариуцлага хүлээх гуравдагч этгээдтэй уг мэдээ материалыг нь олон нийтэд нээлттэй болгохоор зөвшилцөөгүй;
- ж. Ховор амьтдын төрөл зүйлийн үржих газар зэрэг байгаль орчинтой холбогдох мэдээлэл;

Дээр дурдсан татгалзах үндэслэлүүдийг нийтийн ашиг сонирхол болон тухайн хүссэн мэдээлэл нь хүрээлэн буй орчинд нөлөөлөх ялгарах бодистой холбоотой эсэхийг харгалзан хязгаарлагдмал хүрээнд ойлгоно.

5. Байгаль орчны хүссэн мэдээлэл нь төрийн албан тушаалтанд хамаарахгүй тохиолдолд тухайн албан тушаалтан нь уг мэдээлэлд хамаарах холбогдох албан тушаалтны талаар эсхүл тухайн хүсэлтийг уг албан тушаалтанд шилжүүлж, энэ талаар хүсэлт гаргагчид аль болох даруй мэдэгдэнэ.
6. Талууд нь энэ зүйлийн 3 (с) болон 4-т дурдсаны дагуу олон нийтэд хаалттай мэдээллээс нууцлалыг нь алдагдуулахгүйгээр тусгаарлан салгах боломжтой тохиолдолд төрийн албан тушаалтан нь тэрхүү байгаль орчны хүссэн мэдээллийг нээлттэй болгох явдлыг баталгаажуулна.
7. Хүсэлтийг хангахаас татгалзсан хариу өгөхдөө хүсэлтийг бичгээр гаргасан бол эсхүл өргөдөл гаргагч хүссэн бол хариуг бичгээр өгнө. Хүсэлтийг хангахаас татгалзахдаа тийнхүү хангахаас татгалзсан шалтгааныг дурдахаас гадна 9-р зүйлд дурдагдсан тойм процессын талаарх мэдээллийг мөн өгнө. Хүссэн мэдээллийн цар хүрээнээс хамааран хүсэлт гаргаснаас хойш 2 сар хүртэлх хугацаа шаардагдахаас бусад тохиолдолд, хүсэлтийг хангахаас татгалзсан хариуг аль болох нэн даруй, нэг сараас дээшгүй хугацааны дотор өгнө. Хугацаа сунгасан талаар болон үүний шалтгааны талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
8. Талууд нь холбогдох төрийн байгууллагууддаа мэдээллийг төлбөртэй өгөхийг зөвшөөрч болох ба төлбөрийн хэмжээ нь зохих хэмжээнээс хэтэрч болохгүй. Мэдээллийг төлбөртэй өгөх төрийн байгууллага нь төлбөр төлөх, төлбөрийг урьдчилан төлөх тохиолдлуудыг багтаасан төлбөрийн хуваарийг нээлттэй болгоно.

### Зүйл 5

#### **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ, ТҮГЭЭХ**

1. Талууд нь дараах байдлыг баталгаажуулна:
  - а. Төрийн байгууллага, албан тушаалтнууд нь тус тусын ажил үүрэгт хамаарах байгаль орчны мэдээллийг хадгалан, шинэчилж байна.
  - б. Байгаль орчинд ихээр нөлөөлөхүйц, шинээр санаачилж болох болон хүчин төгөлдөр буй үйл ажиллагааны талаарх зохих мэдээллийг төрийн байгууллага, албан тушаалтнуудад хүргэж байх албан ёсны тогтолцоог бий болгох
  - в. Хүний үйл ажиллагаа, эсхүл байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүний эрүүл мэнд, байгаль орчинд болзошгүй аюул учрах үед уг аюулын хор хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад туслах боломж олон

- нийтэд олгох үүднээс түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх бүх мэдээллийг уг аюулд өртөж болох нутгийн иргэдэд нэн даруй, хойшлуулахгүйгээр тараана.
2. Талууд нь үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд, төрийн байгууллага, албан тушаалтнуудаас байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох арга нь ил тод байх, байгаль орчны мэдээллийг олон нийтэд өгөх механизм нь үр нөлөөтэй байх, үүний дотор:
    - а. Холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнуудын хариуцаж буй байгаль орчны мэдээллийн төрөл, цар хүрээний талаарх хангалттай мэдээлэл, тэдгээр мэдээллийг нээлттэй болгож буй үндсэн нөхцөл, мэдээлэл олж авах процесс
    - б. Практик зохицуулалтыг бүрдүүлж, дэмжсэн байх, тухайлбал:
      - i. Олон нийт олж авч болохуйц жагсаалт, бүртгэл, файлууд
      - ii. Энэхүү Конвенцийн дагуу олон нийт мэдээлэл олж авахад нь албан тушаалтнуудыг туслахыг шаардсан
      - iii. Холбоо барих хаягтай
    - в. Энэ зүйлийн 2 дах заалтын (б) дэд хэсгийн (i)-д хамаарах жагсаалт, бүртгэл, файлуудад агуулагдаж буй байгаль орчны мэдээллийг үнэ төлбөргүй өгөх явдлыг баталгаажуулна.
  3. Талууд нь олон нийтийн телекоммуникацийн сүлжээгээр дамжуулан тэдэнд хялбар аргаар хүргэж болох цахим мэдээллийн санд байгаль орчны мэдээллийг үе шаттайгаар байршуулах явдлыг баталгаажуулна. Ийм хэлбэрийн мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байвал зохино. Үүнд:
    - а. Энэ зүйлийн 4-т дурдсан байгаль орчны төлөв байдлын талаарх тайлан мэдээ
    - б. Байгаль орчин, түүнтэй холбоотой хууль тогтоомжийн эх текстүүд
    - в. Байгаль орчин, түүнтэй холбоотой бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр болон байгаль орчны гэрээ хэлэлцээрүүдийг зохих хэмжээгээр
    - г. Энэ хэлбэрийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байлгах нь энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тэдгээр мэдээлэл нь цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй болсон талаарх бусад мэдээллүүд
  4. Талууд нь гурав, эсхүл дөрвөн жилээс хэтрүүлэхгүйгээр тогтмол хугацаанд байгаль орчны төлөв байдлын үндэсний тайланг, үүний дотор хүрээлэн буй орчны чанар, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээллийг хэвлүүлж олон нийтэд түгээнэ.
  5. Талууд нь олон нийтэд тараах зорилгоор хууль тогтоомжийн хүрээнд дор дурдсан арга хэмжээг авна. Үүнд:
    - а. Байгаль орчинтой холбоотой бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын болон хууль тогтоомжийн баримт бичгүүд, түүнчлэн засгийн газрын янз бүрийн түвшинд боловсруулагдсан, тэдгээр баримт бичгүүдийн хэрэгжилтийн талаарх явцын тайлангууд
    - б. Байгаль орчны асуудлаарх олон улсын гэрээ хэлэлцээр, конвенциуд
    - в. Байгаль орчны асуудлаарх бусад ач холбогдол бүхий олон улсын баримт бичгүүд
  6. Талууд нь үйл ажиллагаагаараа байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж буй аж ахуй эрхлэгчийг өөрсдийнхөө бүтээгдэхүүн, үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар сайн дурын эко-шошго, эко-аудитын схем, эсхүл бусад арга хэрэгслийг ашиглан олон нийтэд тогтмол мэдээлж байхыг хөхиүлэн дэмжинэ.
  7. Талууд нь:
    - а. Байгаль орчны үндсэн бодлогын саналыг багцлахад чухал бөгөөд холбогдолтой эсэхийг харгалзсан фактууд, фактуудын анализүүдийг нийтэлнэ.

- б. Энэхүү Конвенцийн хүрээнд хамаарах асуудлаар олон нийттэй харилцах, тайлбар материалуудыг хэвлүүлэх болон бусад хэлбэрээр хүртээмжтэй болгоно.
- в. Төрийн бүх түвшний байгууллагуудаас үзүүлэх, байгаль орчны чиглэлийн төрийн үйлчилгээний нөхцөл, үүргийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг зохих хэлбэрээр нь хангана.
8. Талууд нь хэрэглэгчдэд мэдээлэлд суурилан - байгаль орчныг харгалзсан сонголт хийх боломж олгох үүднээс аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл өгөх явдлыг баталгаажуулсан механизмыг бий болгоно.
9. Талууд нь олон улсын холбогдох процессыг харгалзан, стандартчилагдсан тайлагнах механизмыг ашиглан нэгтгэсэн, олон нийтэд хүртээмжтэй, сайтар зохион байгуулагдсан компьютержсэн мэдээллийн сангийн бүртгэлийн эмх цэгцтэй үндэсний хэмжээний системийг аажмаар эхлүүлэх алхмыг тавина. Уг систем нь тусгай объект, бүтээгдэхүүнүүд, үүний дотор онцгой төрлийн үйл ажиллагаанаас авахуулаад байгаль орчны асуудлаарх хэвлэл мэдээллийн ажиллагаа, газрын нөхөн сэргээлт болон хог хаягдлыг байршуулах цэг хүртэлх, үүний дотор ус, эрчим хүч, нөөц ашиглалт, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг багтаана.
10. Энэхүү зүйлийн аль ч заалт нь Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3, 4 дэх заалтын дагуу байгаль орчны тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоос татгалзах Талуудын эрхийг хязгаарлахгүй.

## Зүйл 6 **ТОДОРХОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЭРХ**

1. Талууд нь:
- а. Энэхүү Конвенцийн Хавсралт 1-д санал болгож буй үйл ажиллагаануудыг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэхдээ энэ зүйлд дурьдсан заалтуудыг хэрэглэнэ.
  - б. Үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд энэхүү Конвенцийн Хавсралт 1-д дурдагдаагүй бөгөөд байгаль орчинд тодорхой нөлөөлөл үзүүлж болох үйл ажиллагаануудыг шийдвэрлэхдээ энэ зүйлд дурьдсан заалтуудыг хэрэглэнэ. Энэ хүрээнд талууд нь санал болгож, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй тэдгээр үйл ажиллагаа нь дээр дурьдсан зүйл заалтуудад нийцэж буй эсэхийг тодорхойлно.
  - в. Үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрсөн бол тодорхой хэргийн шинжээс хамааруулан энэхүү Конвенцийн зүйл заалтыг хэрэглэх нь дотоодын батлан хамгаалах салбарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж тухайн улс үзсэн тохиолдолд энэ чиглэлийн үйл ажиллагаанд Конвенцийн зүйл заалтыг хамааруулахгүйгээр шийдвэрлэж болно.
2. Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад дор дурдсан асуудлуудын талаар нийтээр нь болон ганцаарчлан хамгийн боломжтой хувилбараар аль болох эрт, цаг хугацааг харгалзсан, үр дүнтэйгээр, зохих арга замаар, холбогдох талуудад мэдээлнэ. Үүнд:
- а. Шийдвэрлэх шаардлагатай санал болгож буй үйл ажиллагаа болон өргөдөл
  - б. Гарч болох шийдвэрийн төрөл, шийдвэрийн төсөл
  - в. Шийдвэр гаргах үүрэг бүхий төрийн албан тушаалтан
  - г. Мэдээллээр хангах хугацаа зэргийг багтаасан тойм процесс, үүнд:
    - Үйл явцыг эхлүүлэх
    - Олон нийт оролцох боломж
    - Олон нийтийн хэлэлцүүлэг хийх бол уг арга хэмжээг зохион байгуулах газар, хугацаа
    - Олон нийтээр хянуулах зорилгоор холбогдох мэдээллийг байршуулсан газар болон мэдээллийг олж авч болох төрийн байгууллага, албан тушаалтныг тодорхой заах



- Асуулт, тайлбарыг шилжүүлж болох холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан болон бусад албаны этгээдүүд, тийнхүү шилжүүлэх цагийн хуваарь
  - Санал болгож буй үйл ажиллагаатай холбоотой, байгаль орчны ямар мэдээлэл байгаа тухай болон
- д. Тухайн үйл ажиллагаа нь үндэсний болон хил дамнасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний процессын асуудал болох тухай баримт
3. Олон нийтийн оролцооны процесс нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурьдсаны дагуу олон нийтэд мэдээлэхэд болон олон нийт байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах процесст бэлтгэх, үр дүнтэй оролцох хангалттай хугацаа олгосон, өөр өөр үе шатанд зориулсан боломжит хугацаатай байна.
  4. Талууд нь санал болгож буй бүх үйл ажиллагаанууд нь нээлттэй бөгөөд үр нөлөөтэй байх нөхцлийг бүрдүүлэх үүдээс олон нийтийн оролцоог эртнээс хангана.
  5. Зөвшөөрөл авахаар өргөдөл гаргагчид тийнхүү өргөдөл гаргахаасаа өмнө холбогдох олон нийтийг тодорхойлох, тэдэнтэй хэлэлцүүлэг хийх, өргөдлийнхөө зорилгын талаарх мэдээллээр хангах явдлыг Талууд хөхиүлэн дэмжинэ.
  6. Энэхүү Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгүүдийн дагуу дотоодын хууль тогтоомжоор тогтоосон журмаар гаргасан хүсэлтэд үндэслэн энэ зүйлд дурьдагдсан олон нийтийн оролцооны процесст хамаарах шийдвэр гаргахтай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоос татгалзах Талуудын эрхийг хөндөхгүйгээр үнэ төлбөргүйгээр, аль болох даруй өгөхийг эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнуудаас шаардана.

Холбогдох мэдээлэл гэдэгт 4 дүгээр зүйлд дурьдагдсан заалтуудыг хөндөхгүйгээр, дор хаяж дараах асуудлуудыг багтаана:

- а. Санал болгож буй үйл ажиллагаа явагдах газар, материаллаг болон техникийн шинж чанарын тодорхойлолт, үүний дотор тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд гарах дулаан ялгаруулалт болон хаягдлын тооцоо
  - б. Санал болгож буй үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийн тодорхойлолт
  - в. Нөлөөлөл, түүний дотор дулаан ялгаруулалтыг бууруулах, урьдчилан сэргийлэхээр төлөвлөж буй арга хэмжээний тодорхойлолт
  - г. Дээрх мэдээллийн техникийн бус хураангуй
  - д. Өргөдөл гаргагчаас судалсан үндсэн хувилбаруудын тойм
  - е. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар олон нийтэд мэдээлбэл зохих цаг хугацаанд дотоодын хууль тогтоомжийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтнаас бэлтгэх үндсэн тайлангууд болон зөвлөмжүүд
7. Олон нийтийн оролцооны үйл явцад олон нийтийг бичгээр эсхүл боломжтой тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгээр болон өргөдөл гаргагчтай ганцаарчилсан асуулгаар төлөвлөж буй үйл ажиллагаатай нь холбоотой гэж үзэж буй тайлбар, мэдээлэл, дүн шинжилгээ, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгоно.
  8. Талууд нь тухайн шийдвэрт зохих тайлбар өгөх нь олон нийтийн оролцооны бодит үр дүн болох явдлыг баталгаажуулна.
  9. Талууд нь төрийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргах үед зохих процессын дагуу олон нийтэд нэн даруй мэдэгдэх явдлыг баталгаажуулна. Талууд нь гарсан шийдвэрийн эх текстийг шийдвэрийн үндэслэл шалтгааны хамтаар олон нийтэд нээлттэй болгоно.
  10. Талууд нь төрийн байгууллага, албан тушаалтнууд нь энэ зүйлийн 1-д дурьдсан үйл ажиллагааны хэрэгжих нөхцлийг дахин авч үзэх, боловсронгуй болгох үед энэ зүйлийн 2-оос 9 дэх заалтууд нь *mutatis mutandis* байдлаар, тохирох үед нь үйлчлэх явдлыг баталгаажуулна.

11. Талууд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд практикт нийцэх хэмжээгээр нь генийн өөрчлөлттэй организмыг хүрээлэн буй орчинд зориудаар бүтээхийг зөвшөөрөх эсэх шийдвэрийн талаарх энэ зүйлийн заалтуудыг хэрэглэнэ.

### Зүйл 7

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР ДЭХ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО**

Талууд нь байгаль орчны аливаа төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулахад олон нийтийг оролцуулахад чиглэсэн ил тод, шударга бүтэц бүхий, практикт нийцсэн зохицуулалтыг бий болгоно. Энэхүү бүтэц нь 6 дугаар зүйлийн 3, 4, 8 дахь заалтуудад заасан шалгуурыг хангасан байна. Холбогдох албан тушаалтнууд нь Конвенцийн зорилгыг анхааран оролцооны үйл явцад оролцуулж болох олон нийтийг тодорхойлно. Талууд нь байгаль орчны бодлого боловсруулахад олон нийт оролцох боломжийг хангахыг эрмэлзэнэ.

### Зүйл 8

## **ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР БҮХИЙ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН АКТ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО**

Талууд нь байгаль орчинд ноцтой нөлөө учруулж болох эрх зүйн үр дагавар бүхий хэм хэмжээ тогтоосон акт боловсруулах явцдаа уг актын төслийн бүх хувилбарууд нийтэд нээлттэй байх, холбогдох үе шатанд олон нийтийг үр дүнтэй оролцуулах явдлыг хангана. Энэ хүрээнд дараах алхмуудыг авч хэрэгжүүлнэ:

- а. Үр дүнтэй оролцоог хангах хангалттай хугацааг тохирсон байх
- б. Журмын төслийг хэвлэх болон өөр бусад байдлаар олон нийтэд хүртээмжтэй болгох
- в. Шууд болон төлөөлөгчөөрөө уламжлан тайлбар гаргах боломжийг ОЛОН нийтэд олгох

Олон нийтийн оролцооноос гарах үр дүнг аль болох хэтийг харж тооцоолно.

### Зүйл 9

## **ЗӨРЧИГДСӨН ЭРХЭЭ ХАМГААЛУУЛАХ**

1. Энэхүү Конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу мэдээлэл олж авахаар гаргасан хүсэлтийг нь үл ойшоосон, хууль бусаар татгалзсан, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зохих түвшинд хариу өгөөгүй буюу гаргасан хүсэлтэд өөр бусад байдлаар хариулт өгөөгүй гэж үзэж буй хэн ч хуулийн дагуу байгуулагдсан шүүх болон бусад хараат бус, төвийг сахисан этгээдээр хянуулах эрхтэй болохыг Талууд дотоодын хууль тогтоомжоороо баталгаажуулна.

Зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхийг хангахдаа үнэ төлбөргүй, эсхүл хямд зардлаар төрийн байгууллага, албан тушаалтнаар гомдлоо шийдвэрлүүлэх, эсхүл шүүхээс бусад хараат бус, төвийг сахигч этгээдээр хянуулах, хуулийн дагуу байгуулагдсан, шуурхай процессоор тухайн иргэнийг хангана.

Энэхүү заалтын дагуу гарах эцсийн шийдвэр нь тухайн хүссэн мэдээллийг хариуцаж буй төрийн байгууллага, албан тушаалтанд хууль зүйн үүргийг бий болгоно. Аливаа шалтгааныг үүний дотор мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг зайлшгүй бичгээр өгнө.

2. Талууд нь дотоодын хууль тогтоомжийнхоо хүрээнд, холбогдох олон нийтэд хамаарах:

- а. Хангалттай ашиг сонирхолтой, эсхүл

- б. Талуудын захиргааны процессын хуулиар урьдчилсан нөхцөл шаарддаг бол эрхээ баталгаажуулахыг эрмэлзэж буй

гишүүд нь энэхүү Конвенцийн 6 дугаар зүйл, мөн дотоодын хууль тогтоомжид тусгагдсан болон энэ зүйлийн 3 дахь заалтад дурьдсантай зөрчилдөхгүй тохиолдолд Конвенцийн бусад холбогдох заалтуудад хамаарах аливаа шийдвэр, актыг материаллаг болон процессын эрх зүйн зохицуулалтын дагуу хууль ёсны эсэхийг хянуулахаар хуулийн дагуу байгуулагдсан шүүх болон бусад хараат бус, төвийг сахигч этгээдэд хандах эрхийг нь баталгаажуулна.

Хангалттай ашиг сонирхол ба эрхээ баталгаажуулахыг эрмэлзэж буй явдлыг дотоодын хууль тогтоомж болон холбогдох олон нийтэд эрхээ хамгаалуулах өргөн эрхийг олгох талаарх энэхүү Конвенцийн зорилготой уялдаатайгаар тодорхойлно. Конвенцийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад дурьдсан шаардлагуудыг хангаж буй төрийн бус байгууллагуудыг энэ зүйлийн 2 дахь заалтын (а)-д дурьдсан зорилгын хувьд хангалттай гэж үзнэ. Эдгээр байгууллагуудыг мөн заалтын (б)-д дурьдсаныг хангасан гэж үзэж болно.

Энэ зүйлийн 2 дахь заалт нь захиргааны журмаар хянах процесст мөн хамаарах бөгөөд шүүхээр хянан шийдвэрлүүлэхээс өмнө захиргааны журмаар шийдвэрлүүлэхийг шаарддаг үндэсний хууль тогтоомжийн шаардлагад нөлөөлөхгүй.

3. Талууд нь энэ зүйлийн 1 болон 2 дахь заалтад дурьдсан хяналтын процессыг хөндөхгүйгээр дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байвал дотоодын байгаль орчны хууль тогтоомжийг зөрчиж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, албан тушаалтнуудаас гаргасан, хүчингүй болгосон актуудын талаар шүүхийн болон захиргааны журмаар гомдол гаргах олон нийтийн эрхийг нь баталгаажуулна.
4. Энэ зүйлийн 1 дэх заалтыг хөндөхгүйгээр 1, 2 болон 3 дахь заалтуудад дурьдагдсан процесс нь зөрчигдсөн эрхийг зохих түвшинд үр дүнтэйгээр сэргээх явдлыг үүний дотор албан ёсоор шийдвэр гаргах, тэгш, шударга, цаг үеэ олсон бөгөөд хэт өндөр үнэтэй биш байх явдлыг хангана. Энэ зүйлийн дагуу гарах шийдвэрийг бичгээр өгөх буюу тэмдэглэл үйлдэнэ. Шүүхийн болон бусад эрх бүхий субъектүүдийн шийдвэр нь олон нийтэд хүртээмжтэй байна.
5. Энэ зүйлийн заалтуудын цаашдын үр нөлөөг хангахын тулд талууд захиргааны болон шүүхийн журмаар өргөдөл, гомдол хэрхэн гаргах талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх явдлыг баталгаажуулах ба зөрчигдсөн эрхээ хамгаалуулахад тулгарах санхүүгийн болон бусад бэрхшээлүүдийг арилгах, бууруулахад чиглэсэн тохиромжтой механизмыг бий болгох явдлыг анхаарна.

## **Зүйл 10**

### **ТАЛУУДЫН УУЛЗАЛТ**

1. Талуудын эхний уулзалтыг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор хийнэ. Талууд өөрөөр шийдвэрлээгүй эсвэл аль нэг Талаас бичгээр шаардсан бөгөөд уг шаардлага нь Европын Эдийн Засгийн Хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар уламжлан гэрээний бүх Талуудаар зургаан сарын турш хэлэлцэгдэж, Талуудын гуравны нэгээс доошгүй хувийн дэмжлэг авснаас бусад

- тохиолдолд Талуудын ердийн уулзалтыг эхний уулзалтаас хойш хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа хийнэ.
2. Талууд уулзалтаараа тогтсон хугацаанд Талуудаас ирүүлсэн тайланд үндэслэн энэхүү Конвенцийн хэрэгжилтийг тогтмол дүгнэх ба энэ зорилгын үүднээс:
    - (а) Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд чиглэсэн бодлого, хууль эрх зүйн болон арга зүйн чиг хандлагуудыг дүгнэн цаашид сайжруулах талаар хэлэлцэнэ;
    - (б) Энэхүү Конвенцийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс Конвенцийн нэг ба түүнээс олон талын нэгдэн орсон, хоёр болон олон талт гэрээнүүдийг байгуулах, хэрэгжүүлэх, бусад арга хэмжээг зохион байгуулах явцад олж авсан туршлага мэдээллээ харилцан солилцоно;
    - (в) Энэхүү Конвенцийн зорилгыг бүх талаар хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Европын Эдийн Засгийн Хорооны холбогдох байгууллагууд болон бусад эрх бүхий олон улсын байгууллага, тусгай хороодын үйлчилгээг боломжтой тохиолдол бүрд эрэлхийлнэ;
    - (г) Зайлшгүй шаардлагатай тохиолдолд туслах байгууллага байгуулна;
    - (д) Шаардлагатай бол энэхүү Конвенцид нэмэлт гэрээ бэлтгэнэ;
    - (е) 14 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх, нэмэлт өөрчлөлтийг батлана;
    - (ё) Гэрээний зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад бүх арга хэмжээг хэлэлцэн хэрэгжүүлнэ;
    - (ж) Талуудын уулзалтын болон туслах байгууллагуудын хуралдааны дэгийг Талуудын эхний уулзалтаар хэлэлцэн батлана.
    - (з) Бохирдол гаргах болон энэхүү Конвенцийн хавсралтад хамаарч болох бүртгэл эсвэл жагсаалтыг шилжүүлэхтэй холбоотойгоор авч хэрэгжүүлбэл зохих арга хэрэгслүүдийг бий болгох явдлыг оролцуулан энэхүү Конвенцийн 5 дугаар зүйлийн 9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой туршлагыг Талуудын эхний уулзалтаар хэлэлцэж, цаашид уг заалтыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох арга хэмжээний талаар хэлэлцэнэ.
  3. Шаардлагатай бол гишүүдийн зөвшөөрснөөр санхүүгийн зохицуулалтын асуудлыг Талуудын уулзалтаар хэлэлцэж болно.
  4. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Атомын эрчим хүчний олон улсын агентлаг болон энэхүү Конвенцийн гишүүн бус боловч 17 дугаар зүйлийн дагуу Конвенцид гарын үсэг зурсан улс, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны ямар ч байгууллага, түүнчлэн Конвенцийн хамрах асуудлаар ажилладаг засгийн газар хоорондын аль ч байгууллага Талуудын уулзалтад ажиглагчаар оролцож болно.
  5. Талуудын уулзалтад оролцох тухайгаа Европын эдийн засгийн хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргад мэдэгдсэн, гэрээний хамрах асуудлаар ажилладаг аль ч төрийн бус байгууллага тухайн уулзалтад оролцогч Талуудын гуравны нэгээс доошгүй хувь нь татгалзснаас бусад тохиолдолд Талуудын уулзалтад ажиглагчаар оролцож болно.
  6. Энэ зүйлийн 4, 5 дах заалт болон 2 дахь заалтын (ж)-д заагдсан үйл ажиллагааны журам нь уулзалтад оролцох зөвшөөрөл олгох болон холбогдох бусад нөхцлийг зохицуулахад хэрэглэгдэнэ.

## Зүйл 11 САНАЛ ӨГӨХ ЭРХ

1. Энэ зүйлийн 2 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд Конвенцийн бүх талууд саналын нэг эрхтэй байна.

2. Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд эрх хэмжээнийхээ хүрээнд энэхүү Конвенцийн гишүүн өөрийн гишүүдийн тоотой тэнцүү тооны саналын эрхтэй байна. Гишүүд тухайн асуудлаар саналын эрхээ хэрэгжүүлсэн бол уг байгууллага саналын эрх эдлэхгүй.

### **Зүйл 12**

#### **АЖЛЫН АЛБА**

Европын эдийн засгийн хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- (а) Талуудын уулзалтыг бэлтгэх, зохион байгуулах;
- (б) Конвенцийн дагуу Талуудаас хүлээн авсан тайлан болон бусад мэдээллүүдийг Талуудад дамжуулах;
- (в) Талуудаас тодорхойлон оногдуулсан бусад чиг үүрэг.

### **Зүйл 13**

#### **ХАВСРАЛТУУД**

Энэхүү Конвенцийн хавсралтууд Конвенцийн салшгүй хэсэг байна.

### **Зүйл 14**

#### **ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

1. Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Конвенцийн аль ч тал гаргаж болно.
2. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг Европын эдийн засгийн хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргад бичгээр өгөх ба тэр нь уг саналыг хэлэлцэх Талуудын хурлаас 90-ээс доошгүй хоногийн өмнө Конвенцийн бүх Талуудад уламжлан хүргүүлнэ.
3. Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах зөвшилцөлд хүрэх талаар Талууд хүчин чармайлт гаргана. Талуудын хүчин чармайлт үр дүнгүй болсон ба ямар нэгэн зөвшилцөлд хүрээгүй бол Талуудын уулзалтад оролцож санал өгсөн гишүүдийн дөрөвний гурвын дэмжлэгийг авснаар батлагдсан гэж үзнэ.
4. Конвенцийн эхийг Хадгалагч нь энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу батлагдсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлуулах, батлуулах, нэгдэн оруулахаар бүх Талуудад хүргүүлнэ. Гэрээнд хавсралтаар орсоноос бусад нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний Талуудын дөрөвний гурваас доошгүй нь соёрхон батласан, батласан, нэгдэн орсон тухай мэдэгдлийг Хадгалагч хүлээн авсанаас хойш 90 дэх хоног дээр хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш аль нэг тал соёрхон батласан, батласан, нэгдэн орсон бол тийнхүү соёрхон батласан, батласан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсанаас хойш 90 дэх хоног дээрээ уг нэмэлт өөрчлөлт нь тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болно.
5. Энэхүү Конвенцийн хавсралтад орсон нэмэлт өөрчлөлтийг батлах боломжгүй гэж үзсэн Тал нь уг нэмэлт өөрчлөлтийг батласан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 12 сарын дотор энэ тухайгаа Хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. Хадгалагч тийм мэдэгдлийг хүлээн авсан даруй бусад Талуудад мэдэгдэнэ. Нэмэлт өөрчлөлтийн саналыг хүлээн аваагүй Тал өмнөх мэдэгдлээ хэзээ ч өөрчилж болох ба ийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг Хадгалагч хүлээн авсан өдрөөс уг нэмэлт өөрчлөлт нь тухайн талын хувьд үйлчилж эхлэнэ.
6. Талуудын гуравны нэгээс дээшгүй хувь нь татгалзсан мэдэгдэл хийгээгүй бол энэ зүйл 4 дэх хэсэгт заасны дагуу Конвенцийн хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай Хадгалагчаас мэдээлснээс хойш 12 сарын хугацаа дуусмагц уг нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 5 дахь заалтад дурьдсаны дагуу татгалзсан хариу ирүүлээгүй Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

7. Энэхүү зүйлд заасан ёсоор “уулзалтад оролцсон, санал өгсөн тал” гэдэг нь Талуудын уулзалтад биечлэн оролцож, дэмжсэн эсвэл эсрэг санал өгсөн Талыг ойлгоно.

### **Зүйл 15**

#### **ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

Конвенцийн заалтуудтай холбоотой маргааныг талуудын харилцан яриа хэлэлцээрт тулгуурлан шүүхийн бус аргаар шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт зохицуулалтыг зөвшилцлийн үндсэн дээр бий болгож болно. Эдгээр зохицуулалтууд нь олон нийтийн оролцоог зохистойгоор хангасан бөгөөд Конвенцтой холбоотой асуудлаар олон нийтээс ирүүлсэн санал гомдлыг хэлэлцэх боломжтой байна.

### **Зүйл 16**

#### **МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

1. Энэхүү Конвенцийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Конвенцийн хоёр болон түүнээс олон тооны Талуудын хооронд маргаан үүссэн бол талууд уг маргааныг эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хичээх бөгөөд маргаан хянан шийдвэрлэх боломжит бусад аргуудыг хэрэглэж болно.
2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй маргааны талаар гэрээнд гарын үсэг зурах, нэгдэн орох, соёрхон батлах үед болон дараа нь Конвенцийн Талууд Хадгалагчид бичгээр мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдсэн Тал нь маргаан шийдвэрлэх дараах хоёр аргын аль нэгийг адил үүрэг бүхий Талтай холбоотойгоор хүлээн авна. Үүнд:
  - (а) Олон улсын Шударга ёсны шүүхэд маргааныг мэдүүлэх
  - (б) Конвенцийн II хавсралтад заасан журмын дагуу маргааныг Арбитраар шийдвэрлүүлэх
3. Маргалдагч талууд энэ зүйлийн 2-т заасан маргаан шийдвэрлэх аргуудыг хоёуланг нь хүлээн зөвшөөрсөн бөгөөд Талууд өөр санал гаргаагүй бол маргааныг зөвхөн Олон улсын Шударга ёсны шүүхэд өргөн мэдүүлнэ.

### **Зүйл 17**

#### **ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ**

Энэхүү Конвенц нь 1998 оны 6 сарын 25-ны өдөр Аархус (Дани улсын) хотод гарын үсэг зурагдах ба түүнээс хойш 1998 оны 12 сарын 21-ний өдрийг хүртэл Нью-Йорк дахь НҮБ-ын төв байранд Европын Эдийн засгийн хорооны гишүүн Улсууд, түүнчлэн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1947 оны 3 сарын 28-ны өдрийн 36 (V) тоот тогтоолын 8 болон 11 дэх хэсэгт заасны дагуу Европын Эдийн засгийн хороонд зөвлөх статус бүхий Улсууд, Европын Эдийн засгийн хорооны гишүүн улсуудын байгуулсан бөгөөд энэхүү Конвенцтой холбоотой шийдвэр гаргах, ялангуяа гэрээнд нэгдэн орох эрх хэмжээг гишүүдээс нь олгосон бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд гарын үсэг зурж болно.

### **Зүйл 18**

#### **ХАДГАЛАГЧ**

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү Гэрээний Хадгалагчийн үүргийг гүйцэтгэнэ.

### **Зүйл 19**

## **СОЁРХОН БАТЛАХ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БАТЛАХ БУЮУ НЭГДЭН ОРОХ**

1. Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан Улсууд болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд энэхүү Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсвэл батлаж болно.
2. Энэхүү Конвенц нь 1998 оны 12 сарын 22-ны өдрөөс эхлэн улсууд болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд нэгдэн орох боломжтой болно.
3. Энэ зүйлийн 2 дахь заалтад дурдсанаас бусад НҮБ-ын гишүүн аль ч улс Талуудын уулзалтын зөвшөөрлөөр энэхүү Конвенцид нэгдэж болно.
4. Энэхүү Конвенцийн 17 дугаар зүйлд дурьдсан Конвенцийн гишүүн байгууллагууд нь түүний аль ч гишүүн нь энэхүү Конвенцид гишүүнээр элсээгүй байсан ч энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн бүх үүргээ биелүүлэх үүрэгтэй. Хэрэв тухайн байгууллагын нэг болон түүнээс дээш тооны гишүүд нь энэхүү Конвенцид гишүүнээр элссэн бол энэхүү Конвенциор хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар тухайн байгууллага болон түүний гишүүд харилцан тохиролцоно. Энэ тохиолдолд тухайн байгууллага, түүний гишүүд нэгэн зэрэг энэхүү Конвенциор олгогдсон эрхүүдийг эдлэж болохгүй.
5. Энэхүү Конвенцийн 17 дугаар зүйлд дурьдсан Конвенцийн гишүүн байгууллагууд нь Конвенцийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ Конвенцид хамаарах асуудлаарх өөрийн эрх хэмжээгээ тодорхой дурьдсан байна. Эдгээр байгууллагууд энэхүү Конвенцтой холбоотой өөрийн эрх хэмжээнд орсон томоохон өөрчлөлтүүдийн талаар Хадгалагчид мэдээлэх үүрэгтэй.

### **Зүйл 20**

#### **ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

1. Энэхүү Конвенц нь түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай арван зургаа дахь баримт бичгийг хүлээн авсанаас хойш ер дэх өдөртөө хүчин төгөлдөр болно.
2. Энэ зүйлийн 1 дэх заалттай холбоотойгоор бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас хадгалуулсан баримт бичиг нь тухайн байгууллагын гишүүдийн хадгалуулахаар илгээсэн баримт бичиг дээр нэмж тоологдохгүй.
3. Энэхүү Конвенцийг соёрхон батласан, батласан буюу нэгдэн орсон тухай арван зургаа дахь баримт бичгийг хүлээн авсанаас хойш Конвенцийг соёрхон батласан, батласан буюу нэгдэн орсон Улсууд болон Конвенцийн 17 дугаар зүйлд дурьдсан байгууллагуудын хувьд энэхүү Конвенц нь тийнхүү соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар хүлээлгэн өгсөнөөс хойш ер дэх хоног дээрээ хүчин төгөлдөр болно.

### **Зүйл 21**

#### **ТАТГАЛЗАЛ**

Тухайн Гишүүний хувьд Конвенц төгөлдөр болсон өдрөөс хойш гурван жилийн дараа аль ч үед Конвенциос татгалзсан тухай мэдэгдлээ Хадгалагчид бичгээр хүлээлгэн өгсөнөөр уг гишүүнийг Конвенциос татгалзсанд тооцно. Тийнхүү татгалзсан тухай мэдэгдлийг Хадгалагч хүлээн авсанаас хойш ер дэх хоногоос уг татгалзал үйлчилж эхлэнэ.

### **Зүйл 22**

#### **ГЭРЭЭНИЙ ЭХ БИЧВЭР**

Англи, Франц, Орос хэл дээр үйлдэгдсэн Конвенцийн эх бичвэрүүд нь адилхан хүчин чадалтай бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдана. Конвенцид гарын үсэг зурахад Гэрчээр оролцох, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Нэгэн мянга есөн зуун ерэн найман оны зургаа дугаар сарын хорин хоёрны өдөр өдөр (Дани) Аархуст бичиглэв.

### Хавсралт 1

#### **6 ДУГААР ЗҮЙЛИЙН 1(а) –Д ДУРЬДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

1. Эрчим хүчний салбар:

- Газрын тос, байгалийн хий боловсруулах байгууламжууд;
- Хий боловсруулах болон шингэрүүлэх байгууламж суурилуулах ажиллагаа;
- Дулааны цахилгааны станцууд болон 50 болон түүнээс дээш мегаваттын дулааны оролт бүхий бусад шатах төхөөрөмжүүд суурилуулах ажиллагаа;
- Коксжуулах зуухнууд;
- Цөмийн эрчим хүчний станцууд болон эвдэрсэн, ашиглагдахаа болисон цөмийн станцууд гэх мэт цөмийн бусад реакторууд (дээд хүчин чадал нь 1 к/ваттаас ихгүй бүтээгдэхүүн судалгааны төхөөрөмж суурилуулах болон задардаг болон өсдөг материалуудыг хадгалах үйл ажиллагаа);
- Ашигласан цөмийн түлшийг дахин боловсруулах байгууламж суурилуулах үйл ажиллагаа;
- Дараахь төрлийн ажиллагаанууд:
  - Цөмийн түлш боловсруулах болон дахин баяжуулах;
  - Ашигласан цөмийн түлш болон өндөр хэмжээний радио идэвхит хаягдлыг боловсруулах;
  - Ашигласан цөмийн түлшнээс гарах эцсийн хаягдалд зориулсан байгууламж суурилуулах;
  - Радио идэвхит цөмийн хаягдлыг дангаар нь байршуулах;
  - Ашиглагдсан цөмийн түлш болон радио идэвхит хаягдлыг үйлдвэрлэлийн байрнаас өөр хадгалах (10 жилээс дээш хугацаагаар хадгалахаар төлөвлөгдсөн);

2. Металл боловсруулах болон үйлдвэрлэх:

- Металлын хүдрийг (сульфидын хүдрийг оролцуулан) хайлуулах, жигнэх байгууламж суурилуулах
- Цагт 2.5 тонноос илүү хэмжээний цутгалт хийх хүчин чадалтай ширэм болон гангийн үйлдвэр байгуулах (анхдагч болон хоёрдогч хайлш)
- Төмөрлөг металл боловсруулах үйлдвэр байгуулах:
  - (i) Цагт 20 тонноос дээш хэмжээний түүхий төмөр бэлтгэх хүчин чадал бүхий хайлуулах үйлдвэрүүд;
  - (ii) 20 мегаваттаас их дулаан хэрэглэдэг 50 киложоулаас их хүчин чадал бүхий алх ашигладаг дарханы газрууд;
  - (iii) Цагт 2 тонноос дээш хэмжээний түүхий гангийн орц бүхий хамгаалалтын хайлмал метал бүрхүүл хэрэглэх;
- Өдөрт 20 тонноос илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хар төмөрлөгийн үйлдвэр;
- Суурилуулах ажиллагаанууд:
  - (i) Хүдэр, баяжмал, хоёрдогч түүхий эд зэргээс металлург, хими, электролитийн аргаар түүхий өнгөт металл гарган авах үйлдвэрлэл;
  - (ii) Өдөрт 4 тонноос дээш хар тугалга, кадми, бусад металлын хувьд өдөрт 20 тонноос их бүтээгдэхүүн хайлуулах хүчин чадалтай; хайлш хийх, дахин боловсруулсан материал гэх мэт өнгөт металл хайлуулах үйлдвэрлэлийг (цэвэршүүлэх, цутгах цех гэх мэт);



30 м<sup>3</sup>-ээс илүү хэмжээтэй тогоо бүхий, электролит болон химийн аргуудыг хэрэглэдэг өнгөлгөөний металлын үйлдвэр байгуулах;

3. Ашигт малтмалын үйлдвэрлэл

- Өдөрт 500 тонноос дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий эргэлдэх зуухтай цемент зуурагч, өдөрт 50 тонноос дээш бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай шохой зуурагч, өдөрт 50 тонноос дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бусад төрлийн зуух суурилуулах;
- Асбест болон асбестын орцтой бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах;
- Хоногт 20 тонноос дээш шил хайлуулах хүчин чадалтай шил хайлуулах үйлдвэр /ширхэглэг шилийг оролцуулан/;
- Хоногт 20 тонноос дээш эрдэс хайлуулах хүчин чадалтай эрдсийн хайлуулах үйлдвэр байгуулах;
- Хоногт 75 тонноос дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл 4 м<sup>3</sup>ээс дээш бүтээгдэхүүн шатаах, нэг удаагийн ажиллагаагаар 3 кг/м<sup>3</sup> түүхий эд шатаах хүчин чадалтай, хайлуулах аргаар керамик бүтээгдэхүүн гаргах үйлдвэр; ялангуяа дээврийн хавтан, тоосго, шатдаггүй, ваар, шавар болон шаазан эдлэлийн үйлдвэр;

4. Химийн үйлдвэр: Энэ хэсэгт хамаарах үйл ажиллганы төрлүүд нь дан болон дор дурьдсан (а)-аас (б) хүртэл жагсаалтад орсон нийлмэл бодисуудыг химийн аргаар боловсруулах үйлдвэрлэлтэй холбоотой болно:

(а) Дараахь төрлийн органик бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах:

- (i) Энгийн нүүрс устөрөгч (шугаман болон цагираг, ханасан болон ханаагүй, тосон болон үнэртэй);
- (ii) Спирт, альдегид, кетон, карбон хүчлүүд, нийлмэл эфирүүд, цуунууд, эфир, хэт ислүүд, цавуулаг резинүүд гэх мэт хүчилтөрөгч агуулсан нүүрс устөрөгчүүд;
- (iii) Хүхэрлэг нүүрс устөрөгчүүд;
- (iv) Амин, амид, азотлог нэгдлүүд, нитро болон нитратын нэгдлүүд, нитрил, цианид, изоцианид гэх мэт азотлог нүүрс ус төрөгчүүд;
- (v) Фосфор агуулсан нүүрс устөрөгчүүд;
- (vi) Органик металлын нэгдлүүд;
- (vii) Пластик материалууд (полимерүүд, синтетик материалууд, целлюлоз материалууд);
- (ix) Синтетик резинүүд;
- (x) Будагч бодисууд, пигментүүд;
- (xi) Гадаргуу үүсгэгч бодисууд, өнгөц идэвхитэй бодисууд;

(б) Органик бус химийн бодис бүхий бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах:

- (i) Аммон, хлор, хлорт устөрөгч, фтор болон фторт устөрөгч, нүүрсхүчил, хүхэрт нэгдлүүд, азотын исэл, устөрөгч, хүхрийн давхар исэл, карбонил хлор гэх мэт хийнүүд;
  - (ii) Хромын хүчил, фторт устөрөгчийн хүчил, фосфорын хүчил, азотын хүчил, хлорт устөрөгчийн хүчил, хүхрийн хүчил, олеум, хүхэрлэг хүчил гэх мэт хүчлүүд;
  - (iii) Аммонийн хэт исэл, калийн хэт исэл, натрийн хэт исэл гэх мэт сууриуд;
  - (iv) Хлорт аммони, кали хлорат, кали карбонат, перборат, мөнгөний нитрат зэрэг давсууд;
  - (v) Металлын оксид болон кальцийн карбид, соликон, цайрын карбид гэх мэт органик бус нэгдлүүд;
- (в) Фосфор, азот, кали суурьтай бордоо гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг химийн үйлдвэрүүд (дан болон нийлмэл бордоонууд);

- (г) Эмийн бүтээгдэхүүний түүхий эд болдог ургамлын тариалан, биоцид гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэх химийн үйлдвэр;
- (д) Хими, биологийн аргаар эм, эмнэлгийн зориулалттай үндсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр;
- (е) Тээлгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх химийн үйлдвэр;
- (ё) Хими, биологийн аргыг хэрэглэн тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүн, уураг, фермент гэх мэт бусад төрлийн уураг үйлдвэрлэх химийн үйлдвэр;

5. Хог хаягдлын менежмент:

- Шатаах, нөхөн сэргээх, химийн боловсруулалт болон хортой хог хаягдлыг булшлах байгууламжууд;
- Цагт 3 тонноос илүү хэмжээний эмнэлгийн хог хаягдал шатаах хүчин чадалтай бүхий байгууламжууд;
- Өдөрт 50 тонноос дээш хэмжээний хоргүй хог хаягдал устгах, байршуулах хүчин чадал бүхий байгууламжууд;
- Өдөрт 10 тонноос дээш бөгөөд идэвхигүй хаягдал булшлахыг оролцуулахгүйгээр нийтдээ 25 000 тонноос дээш хаягдлыг хүлээн авч булшлах ажиллагаа;

6. 150 000 хүний хэрэглээнээс дээш хэмжээний бүхий бохир ус зайлуулах хүчин чадал (боловсруулах) байгууламж;

7. Дараахь зориулалт бүхий үйлдвэрийн байгууламжууд:

- (а) Мод болон бусад хатуу материалаас гаралтай үртэс үйлдвэрлэх;
- (б) 20 тонноос дээш хэмжээний цаас болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий цаас, цаасан хавтангийн үйлдвэр;

8. (а) Алсын төмөр замын шугам байгуулах болон 2100 м, түүнээс илүү урттай буух, хөөрөх зурвас бүхий нисэх онгоцны буудал байгуулах;

(б) Энгийн болон хурдны зам байгуулах;

(в) 10 км-ээс илүү урттай, дөрөв болон түүнээс олон эгнээтэй зам шинээр байгуулах, өөрчлөн засварлах, 2 болон түүнээс цөөн эгнээтэй замыг 4 эгнээтэй болгон өргөсгөх.

9. (а) 1350 тонноос дээш хэмжээтэй ачаа болон зорчигч тээвэрлэх зөвшөөрөл бүхий дотоодын усан зам, усан замын буудал байгуулах;

(б) Худалдааны портууд болон 1350 тонноос дээш даацтай, дотоодын хуурай газар болон гадаад дахь усан зогсоолуудын хооронд ачаа тээвэрлэх хөлөг онгоцууд /хүн тээврийн жижиг усан онгоцыг тооцохгүй/;

10. 10 сая куб метрээс илүү хэмжээний ус хэрэглэх газрын гүний усан байгууламж болон гүний усаар тэжээгддэг байгууламж байгуулах;

11. (а) Жилд 100 сая куб метрээс илүү хэмжээний усны шилжүүлэг хийх чадал бүхий усны хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор барьж буй усны ургал өөрчлөх үйл ажиллагаа;

(б) Өөрчлөн урсгаж байгаа усны хэмжээ нь нийт урсацын 5 хувиас илүү тохиолдолд олон жилийн дундаж урсацын хэмжээ нь 2000 тонн куб метрээс их байдаг голын гольдрил өөрчлөх бүх үйл ажиллагаа;

Дээрх 2 тохиолдол яндан хоолойгоор урсгаж байгаа ундны усыг тооцохгүй.

12. Өдөрт 500 тонноос дээш газрын тос, өдөрт 500 000 метр кубаас илүү байгалийн хий олборлож байгаа бизнесийн зорилгоор газрын тос, байгалийн хий олборлох үйл ажиллагаа;
13. 10 сая тонноос дээш хэмжээний ус хуримтлуулан байршуулах хүчин чадал бүхий далан болон усан бусад байгууламжууд;
14. Байгалийн хий, газрын тос болон бусад химийн гаралтай бодис дамжуулах 800 мм-ээс дээш өргөн, 40км-ээс урт шугам хоолойнууд;
15. Дараахь хэмжээнээс илүү тоо толгой бүхий гахай болон шувуу үржүүлэх аж ахуй байгуулах:
  - (a) 40 000 дээш тооны шувууны байр;
  - (b) 2 000 тооны үржүүлгийн гахайн байр (30 кг-аас дээш жинтэй); эсвэл
  - (c) Хээлтэгч гахай бол 750.
16. 25 га-аас том талбай бүхий ил уурхай, карьер, 150 га-аас том талбайг хамарсан хүлрийн олборлолт;
17. 15 км-ээс илүү урттай, 220 в дамжуулах хүчин чадал бүхий өндөр хүчдэлийн шугам байгуулах;
18. 200 000 тонн болон түүнээс дээш хэмжээний газрын тос, тосон болон химийн бүтээгдэхүүн хадгалах хүчин чадал бүхий агуулах байгуулах;
19. Бусад үйл ажиллагаанууд:
  - Урьдчилан боловсруулах байгууламж (угаах, цайруулах, зөөлрүүлэх гэх мэт), эсвэл өдөрт 10 тонноос дээш хэмжээний хөвөн болон даавуу будах үйлдвэр байгуулах;
  - Өдөрт 12 тонноос дээш хэмжээний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий арьс шир болон ангийн арьс идээлэх, боловсруулах үйлдвэр байгуулах;
    - (a) Өдөрт 50 тонноос дээш гулууз мах үйлдвэрлэх хүчин чадал бүхий нядалгааны газар;
    - (b) Дараах түүхий эдээс хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх:
      - (i) Амьтны гаралтай түүхий эдээс өдөрт 75 тонноос багагүй эцсийн бүтээгдэхүүн (сүүнээс бусад) үйлдвэрлэх;
      - (ii) Ургамлын гаралтай түүхий эдээс өдөрт 300-аас тонноос багагүй хэмжээний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх (улирлын дундаж хэмжээгээр);
      - (iii) Өдөрт 200 тонноос дээш хэмжээний сүү хүлээн авах хүчин чадал бүхий вүү боловсруулах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх (жилийн дунджаар);
  - Өдөрт 10 тонноос дээш хэмжээний амьтны гаралтай махан бүтээгдэхүүнийг устгах, ийм төрлийн хог хаягдлыг боловсруулах ажиллагаа;
  - Жилд 200 тонноос, цагт 150 кг-аас дээш хүчин чадалтай өнгөлгөөний материал боловсруулах, органик уусгагч бодисын орц бүхий бүтээгдэхүүнүүд, ялангуяа сав, баглаа боолт хийх, хэвлэх, хавтаслах, тос ялгаруулах, хатаах, хэлбэржүүлэх, будах, цэвэрлэх, үр тогтоох ажиллагаа;
  - Нүүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх (хатуу шаталтат нүүрс) болон цахилгаанаар сийлэх, шатаах ажиллагаа;
20. 1-19 дэх хэсэгт дурьдагдаагүй боловч үндэсний хууль тогтоомжоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нь олон нийтийн оролцоог шаарддаг бусад бүх үйл ажиллагаанууд;

21. Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээс бусад тохиолдолд энэхүү Гэрээний 6 дугаар зүйлийн 1(а) хэсэг болон дээр дурьдсан үйл ажиллагаануудад хамаарахгүй, 2 жилээс богино хугацаанд хэрэгжих судалгаа, хөгжлийн болон шинэ арга ажиллагаа, бүтээгдэхүүнийг турших үйл ажиллагаанууд;
22. Ямар нэг үйл ажиллагааны аливаа өргөтгөл, өөрчлөлт нь энэхүү хавсралтад дурьдсан шалгуур/хязгаартай нийцсэн бол энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлийн 1(а) хэсэгт хамаарна.

#### Тэмдэглэл

- 1/ Цөмийн цахилгаан станц болон бусад цөмийн эх үүсвэрүүдийн үлдэгдлээс цөмийн түлш, бусад цацраг идэвхит бодис, бохирдлыг байнга цэвэрлэж, саармагжуулна.
- 2/ Энэхүү Конвенцид дурьдсан “нисэх онгоцны буудал” гэдэгт Олон улсын Иргэний нисэхийн байгууллагаас 1944 онд батласан Чикагогийн конвенцийн тодорхойлолттой нийцэж буй нисэх буудлуудыг ойлгоно.
- 3/ Энэхүү Конвенцид дурьдсан “хурдны зам” гэдэгт 1975 оны 11 сарын 15-нд батлагдсан Авто замын олон улсын гол сүлжээний тухай Европын гэрээний тодорхойлолтод дурьдсан буй замуудыг ойлгоно.

## Хавсралт II

### АРБИТР

1. Энэхүү Конвенцийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу арбитр маргааныг мэдүүлсэн Тал нь маргаан, түүний агуулга болон арбитрт хэрэг мэдүүлсэн тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ. Ялангуяа тухайн маргаанд хэрэглэгдэх Конвенцийн зүйл заалт, түүнийг тухайн маргааны хувьд хэрхэн тайлбарлаж, хэрэглэж байгаа талаараа мэдээлнэ. Нарийн бичгийн дарга нарын газар нь дээрх мэдээллийг Конвенцийн бүх Талуудад дамжуулна.
2. Арбитр гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Нэхэмжлэгч болон маргааны бусад талууд тус бүр нэг арбитрчийг сонгох ба тэдгээр нь зөвшилцөж, гурав дахь арбитрчийг томилох бөгөөд тийнхүү томилогдсон арбитрч нь арбитрын шүүх хуралдааны даргалагч байна. Гурав дахь арбитрч нь маргалдагч талуудын харьяалах улсын иргэн, эсвэл байнга оршин суугаа газар нь талуудын харьяалах улс байж болохгүй. Түүнчлэн талуудад ажилладаг эсвэл талуудтай холбоотой өөр маргааныг ямар нэг байдлаар шийдвэрлэхэд оролцсон хүн байж болохгүй.
3. Хоёр дахь арбитрч томилогдсоноос хойш хоёр сарын дотор даргалагч арбитрч томилогдоогүй бол Европын Эдийн засгийн хорооны гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь маргаан бүхий талуудын хүсэлтээр арбитрийн хуралдаан даргалагчийг хоёр сарын дотор томилно.
4. Маргаан бүхий талуудын аль нэг нь арбитрч томилох шаардлагыг хүлээн авсанаас хойш хоёр сарын дотор арбитрчаа сонгоогүй бол маргааны нөгөө тал нь Европын Эдийн засгийн хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргад энэ тухай мэдэгдэх ба тэр нь мэдээллийг хүлээн авснаас хойш хоёр сарын дотор даргалагч арбитрчийг томилно. Арбитрын хуралдаан даргалагч нь томилогдсон даруйдаа арбитрч сонгоогүй талд шаардлага хүргүүлж, хоёр сарын дотор арбитрчаа сонгох талаар мэдэгдэнэ. Энэ хугацаанд арбитрчийг сонгоогүй бол хуралдаан даргалагч нь Европын Эдийн засгийн хорооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргад мэдэгдэж, тэр нь тийнхүү мэдэгдсэнээс хойш хоёр сарын дотор үлдсэн арбитрчийг томилно.
5. Арбитрын хуралдааны шийдвэр нь олон улсын эрх зүй болон энэхүү Конвенцийн зүйл заалтуудтай нийцсэн байна.
6. Энэхүү хавсралтад дурьдсаны дагуу явагдсан арбитрын бүх хуралдаан тус бүр нь өөр өөрийн хуралдааны дэгийг баталсан байна.
7. Материаллаг эрх зүйн болон процессын аль ч асуудлаар гарах арбитрын шийдвэр нь гишүүдийн олонхийн саналаар батлагдана.
8. Арбитрийн шүүх нь маргааны үйл баримтыг тодорхойлоход шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээгээ авч болно.
9. Маргаан бүхий талууд нь арбитрын шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа:
  - (а) Холбогдох бүх баримт бичиг, эд зүйл, мэдээллийг гаргаж өгөх;
  - (б) Шаардлагатай үед гэрч, шинжээчийг дуудах, нотлох баримтыг хүлээн авах боломж олгох;
10. Талууд болон арбитрч нар арбитрын шүүхийн үйл ажиллагааны явцад олж мэдсэн нууцыг хадгалах үүрэгтэй.
11. Арбитрын шүүх нь маргалдагч талуудын хүсэлтээр хамгаалалтын түр арга хэмжээ авахыг зөвлөмжилж болно.
12. Маргалдагч талуудын аль нэг нь арбитрын хуралдаанд хүрэлцэн ирээгүй эсвэл өөрийн шаардлагаа хамгаалаагүй бол нөгөө тал нь арбитрын хуралдааныг үргэлжлүүлэх, эцсийн шийдвэрээ гаргахыг Арбитрын хуралдаанаас шаардаж

- болно. Талуудын хуралдаанд ирээгүй болон маргаж буй шаардлагаа хамгаалаагүй нь хуралдааныг саатуулах үндэслэл болохгүй.
13. Арбитрын шүүх нь тухайн маргаантай холбоотойгоор гарсан сөрөг нэхэмжлэлийг сонсож, хэлэлцэж болно.
  14. Арбитрын шүүх тухайн маргааны онцлогоос хамааран өөрөөр шийдвэрлээгүй бол гишүүдийн урамшуулал гэх мэт арбитрын үйл ажиллагааны зардлуудыг талууд тэнцүү хэмжээгээр хариуцна. Арбитр нь үйл ажиллагааныхаа зардлыг баримтжуулан талуудад хүргүүлнэ.
  15. Маргаанд хууль зүйн сонирхолтой байгаа болон арбитрын шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж болохуйц Конвенцийн аль ч Талууд арбитрын хуралдааны зөвшөөрлөөр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.
  16. Маргаан хянан шийдвэрлэх хугацааг сунгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд арбитрын шүүх нь байгуулагдсанаасаа хойш таван сарын дотор шийдвэрээ гаргана. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг таван сараас илүүгүй хугацаагаар сунгаж болно.
  17. Арбитрын шийдвэр нь түүний үндэслэлийг тайлбарласан баримт бичгийн хамт гарна. Арбитрын шийдвэр нь маргаан бүхий талуудын хувьд эцсийн шийдвэр байна. Арбитрын шүүхийн шийдвэрийг маргаан бүхий талууд болон нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ. Нарийн бичгийн дарга нарын газар нь хүлээн авсан мэдээллээ Конвенцийн бүх Талуудад дамжуулна.
  18. Арбитрын шүүхийн шийдвэрийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор маргаан бүхий талуудын хооронд үүссэн маргааныг талуудын аль нь ч маргааныг хянан шийдвэрлэсэн арбитрт уламжилж болох ба хэрэв тухайн арбитр нь татан буугдсан бол түүнтэй төсөөтэй асуудлыг шийдвэрлэхээр хамгийн түрүүнд байгуулагдсан өөр арбитрт уламжилж болно.